



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ  
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2016 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 6/47

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Засгийн газрын 1995 оны 52 дугаар тогтоол, Удирдлагын зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Архивын хадгаламжийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, түүврийн аргаар баримтанд нягтлан шалгалт хийх ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	О.Баатаржав	Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил эрхэлсэн дэд захирал
Нарийн бичгийн дарга:	С.Ариунболд	Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Саранцацрал	Чанарын менежер
	П.Бямбасүрэн	Сувилгааны арга зүйч
	Ц.Хэрлэнцэцэг	Аж ахуй хариуцсан нягтлан бодогч
	О.Соёл-Эрдэнэ	Статистикч
	Т.Одгэрэл	Өвчний түүх хариуцсан статистикч бага эмч

2. Ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд даалгах нь:

2.1 Архивын тухай хууль, байгууллагын архивын ажлын үндсэн зааврын талаар судлаж, тодорхой мэдлэгтэй болох

020262

2.2 Архивын хадгаламжийн сангийн үйл ажиллагаанд алба бүр үйл ажиллагааныхаа чиглэлээр түүвэрчилсэн байдлаар 5-аас доошгүй баримтанд хяналт хийх


2.3 Хяналт хийсэн баримт бүрт дүн шинжилгээ хийх

2.4 Архивын эрхлэгч С.Тунгалагтамиртай хамтран тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцүүлэг хийх

2.5 Ажлын хэсгийн гишүүн бүр хяналт, шалгалтын талаар тайлан бичих

3. Энэ тушаалын хэрэгжилтийг Удирдлагын зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 21-ний хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч О.Баатаржав, нарийн бичгийн дарга С.Ариунболд нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ